

САНГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ

1997 оны 3 дугаар
сарын 13 ны өдөр

84/
Дугаар 2/97

Улаанбаатар
хот

Нийгмийн даатгалын сангаас олгох
тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд
нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдон
нөхөн олговор олгох арга хэмжээг
зохион байгуулах тухай

«Хүн амын нийгмийн хамгааллын талаар авах зарим арга хэмжээний тухай»
Улсын Их Хурлын 1997 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлэхтэй
холбогдуулан ТУШААХ нь:

Нэг. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халалмжийн сангаас олгох тэтгэвэр,
тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй
болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн
1-д заасан иргэдэд одоо авч байгаа тэтгэвэр, нөхвөрийн хэмжээтэй тэнцэх нөхөн
олговрыг тэдний өндөр насны тэтгэврийн эрх үүсэх хүртэлх хугацаанд олгоход
мөрдөх «Нөхөн олговор олгох журам»-ыг 1 дүгээр хавсралтаар, нөхөн олговортой
холбогдон хотлогдох маягтуудыг 2, 3, 4 дүгээр хавсралтаар тус тус баталж
мөрдүүлсүгэй.

Хоёр. Хөдөлмөр зохицуулалтын албадаар дамжуулан нөхөн олговор олгох
ажлыг зохион байгуулах, тухайн жилд нөхөн олговор авах иргэдийн судалгаа,
шаардагдах хөрөнгийн тооцоо хийж улсын төвлөрсөн төсөвт тусгуулах, тогтоосон
хугацаанд санхүүжилтийн сарын гүйцэтгэлийн мэдээ, улирал, жилийн тайланг
нэгтгэн ирүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж байхыг Хөдөлмөр зохицуулалтын газар
(Ц.ЧИНБАТ)-т даалгасугай.

Гурав. Хөдөлмөр зохицуулалтын газраас ирүүлсэн тухайн жилд олгох нөхөн
олговорт шаардагдах хөрөнгийн төсвийг хянан улсын төвлөрсөн төсөвт тусгах,
түүний хэрэгжилтэд хяналт тавьж байхыг Сангийн яамны Төсвийн бодлогын газар
(Л.ДАШДОРЖ)-т даалгасугай.

САНГИЙН САЙД

[Signature]
П.ЦАГААН

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

[Signature]
Л.ЗОРИГ


3603

10 08 24

360

УХАА...

20/10 В 24



НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д заасан иргэдэд (цаашид нөхөн олговор авагч гэнэ) одоо авч байгаа тэтгэвэр, нөхвөрийн хэмжээтэй тэнцэх нөхөн олговрыг тэдний өндөр насны тэтгэврийн эрх үүсэх хүртэлх хугацаанд олгоход энэхүү журмыг баримтална.

2. Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон дор дурдсан иргэдэд өндөр насны тэтгэврийн эрх үүсэх хүртэлх хугацаанд нөхөн олговор олгоно. Үүнд:

1/ Тэтгэврийн хуулиар тэтгэвэр тогтоолгосон:

а) нийтдээ 32-оос дээш жил ажилласан 55 насанд хүрсэн эрэгтэйчүүд, 27-гоос дээш жил ажилласан 50 насанд хүрсэн болон нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгосон эмэгтэйчүүд;

б) иргэний агаарын тээврийн нисэх бүрэлдэхүүн, инженер техник, диспетчерийн албан тушаалын зэрэглэлтэй ажилтнаар 25-аас доошгүй жил, түймэр мэргүүцэх агаарын харуулын албаны шүхэрчин-гал сөнөөгчөөр 20-иос доошгүй жил алба хаасан иргэд;

в) мэргэжлийн урлагийн байгууллагад гошлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчнөөр 20-иос доошгүй жил, түүнээс 15-аас доошгүй жил уг мэргэжлээр ажилласан иргэд;

г) төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш үүхдээ 6 нас хүртэл нь өсгөж хүмүүжүүлсэн, 15-аас доошгүй жил ажилласан 50 насанд хүрсэн, 20-иос доошгүй жил ажилласан нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгосон эхчүүд;

д) бүрэн хараагүй болон дүлий, одой бөгөөд 15-аас доошгүй жил ажилласан 45 насанд хүрсэн эрэгтэй, 10-аас доошгүй жил ажилласан 40 насанд хүрсэн эмэгтэй.

2/ Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулиар тогтоогдсон:

- а) нийтдээ 32 жил ажилласан 55 нас хүрсэн эрэгтэй, 27 жил ажилласан 50 нас хүрсэн эмэгтэй;
- б) мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн түүнбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, цирк хөгжмийн үдээвэр хөгжимчнөөр 20-иос доошгүй жил уг мэргэжлээрээ ажилласан иргэд;
- в) төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албан хаагч, иргэний агаарын тээврийн нисэх бүрэлдэхүүн, инженер, техник, диспетчерийн албаны албан хаагчийн зэрэглэлтэй ажилтнаар 25-аас доошгүй жил ажилласан иргэд;
- г) эрэгтэй 15-аас доошгүй жил ажилласан 45 насанд хүрсэн, эмэгтэй 10-аас доошгүй жил ажилласан 40 нас хүрсэн бүрэн хараагүй болон дүлий, одой иргэд;
- д) төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчилж авсан 16 хүртэл насны 4, түүнээс дээш өнчин хүүхдээ 6 нас хүртэл нь дангаараа өсгөж хүмүүжүүлсэн 20-иос доошгүй жил ажилласан 50 нас хүрсэн эрэгтэй.

Хоёр. Нөхөн олговор олгох тухай

3. Сангийн яамнаас тухайн сард нөхөн олговорт шаардагдах хөрөнгийг Хөдөлмөр зохицуулалтын газраас ирүүлсэн тооцоо, үндэслэл, хуваарийг баримтлан аймаг, нийслэлийн дүүргийн Хөдөлмөр зохицуулалтын албадад санхүүжүүлж байна.

4. Нөхөн олговрыг Хөдөлмөр зохицуулалтын албанаас ирүүлсэн нэрсийн жагсаалт, нэрийн карт, тэтгэврийн буюу нөхөн олговрын дэвтэр, мэдэгдлийг үндэслэн аймаг, нийслэлийн дүүрэг, сумдын банкны тооцооны касснаас сар бүр олгоно.

5. Банкны байгууллага нөхөн олговор олгосон тухай бүр нөхөн олговор авагчдын нэрийн карт, тэтгэврийн буюу нөхөн олговрын дэвтэрт тэмдэглэл хийж нөхөн олговор олгосон жагсаалтыг сар бүр тогтоосон хугацаанд тухайн аймаг, нийслэлийн дүүргийн Хөдөлмөр зохицуулалтын албадад хүргүүлэх бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг Хөдөлмөр зохицуулалтын газар сар бүрийн 3-ны дотор Сангийн яаманд гаргаж өгнө.

6. Хөдөлмөр зохицуулалтын алба нөхөн олговор авагчийн нөхөн олговрыг зогсоосон буюу нөхөн олговор авах хугацаа нь дууссан тухай мэдэгдсэн нөхцөлд үйлчлэгч банкны тооцооны касс нөхөн олговор авагчийн нэрийн картыг Хөдөлмөр зохицуулалтын албанд хүргүүлнэ.

7. Нөхөн олговрыг зөвхөн нөхөн олговор авагч хүнд өөрт нь олгох бөгөөд хэрэв өөрийн биеэр ирж авах боломжгүй хүмүүс (бусдын асрамжинд байнга байдаг, удаан хугацаагаар эмнэлэгт хэвтсэн, гадаадад яваа)-ийн нөхөн олговрыг оршин суугаа сум, хорооны Засаг даргаас олгосон итгэмжлэх бичигтэй хүнд олгож болно.

5665

10 08 24

Нөхөн олговор авагч эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хугацаанд нөхөн олговрыг олгоно.

9. Нөхөн олговрыг дор дурдсан шалтгаанаар түр буюу бүрмөсөн зогсооно. Үүнд:

- а) өндөр насны тэтгэврийн эрх үүсэх насанд хүрвэл;
- б) нөхөн олговор авагч төрийн алба хаах буюу хөдөлмөрийн гэрээгээр ажиллавал;
- в) бүрэн бус бүрдэлтэй материалаар нөхөн олговор авч байгаа нь илэрвэл;
- г) бусад төрлийн тэтгэвэр, тэтгэмж авч эхэлбэл;
- д) нөхөн олговор авагч хорих ял шийтгэгдвэл;
- е) нөхөн олговор авагч гадаад улсын харьяат иргэн эх орондоо бүрмөсөн буцвал;
- ж) нөхөн олговор авагч нас барвал.

10. Нөхөн олговрыг ямар нэг шалтгаанаар зогсоовол тухайн Хөдөлмөр зохицуулалтын алба нь энэ тухай тэтгэврийн буюу нөхөн олговрын дэвтэр, нэрийн хувийн хэрэг болон холбогдох бусад материалд заавал тэмдэглэл хийж холбогдох банкны байгууллагад албан ёсоор мэдэгдэж байна.

11. Энэхүү журмын 9-ийн а-д заасан нөхөн олговор авагчийн хувийн хэрэг, материалыг уг иргэн тэтгэврийн нас хүрсэн сард нь багтаан тухайн шатны шатны даатгалын байгууллагад албан дагалдах бичигтэй шилжүүлнэ. Нөхөн олговор болон тэтгэврийг давхардуулан олгохгүй.

12. Энэхүү журмын 9-ийн б, в, г, д-д заасан шалтгаанаар нөхөн олговор нь тогтоогдсон иргэдэд төрийн алба хаах буюу хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаа больсон, нөхөн олговор авах материалаа бүрэн бүрдүүлсэн, бусад төрлийн тэтгэвэр, тэтгэмж авахаа зогсоосон болон хорих ял эдэлж дууссаны дараа ажиллах Хөдөлмөр зохицуулалтын албанд ирж бүртгүүлсэн өдрөөс эхлэн нөхөн олговор олгоно.

13. Энэхүү журмын 9-ийн е, ж-д заасан тохиолдолд тухайн иргэний хувийн хэрэг, холбогдох материалыг бүрмөсөн хааж Хөдөлмөр зохицуулалтын албад зохих журмын дагуу хадгална.

14. Нөхөн олговрыг бусад төрлийн ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмжтэй давхардуулан олгохгүй. Нөхөн олговор авагч хэд хэдэн төрлийн тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор авах болсон тохиолдолд тэдгээрийн аль илүүг сонгон авах эрхтэй.

15. Иргэдээс нөхөн олговортой холбогдуулж гаргасан өргөдөл, гомдлыг тухайн шатны Засаг даргын Тамгын газар хүлээн авч шийдвэрлэнэ. Харин тухайн шатны Засаг даргын Тамгын газрын хариу, шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл түүнтэй холбогдсон маргааныг Монгол улсын Хөдөлмөр зохицуулалтын газар болон холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

16. Нөхөн олговор авч байх хугацаандаа хөдөлмөр эрхэлж байсан нь мэдэгдвэл тухайн хугацаанд олгогдсон нөхөн олговрыг уг иргэн эргүүлж төлнө.

385

10 08 2024

[Signature]

17. Нөхөн олговор авагч нь тэтгэврийн буюу нөхөн олговрын дэвтрээ хаяж үлддүүлбэл тэр тухайгаа Хөдөлмөр зохицуулалтын албанд 10 хоногийн дотор мэдэгдэж, өөрийн зардлаар зарлуулан хүчингүй болгож, энэ тухай хэвлэл, мэдээллийн байгууллагын мэдэгдлийг авч ирсэний дараа дахин дэвтрэ олгоно.

18. Нөхөн олговор авагч нь оршин суугаа газраасаа өөр газарт байнга оршин суухаар тогтоосон журмын дагуу шилжвэл тэр тухайгаа харьяалах Хөдөлмөр зохицуулалтын албанд мэдэгдэх үүрэгтэй. Тухайн Хөдөлмөр зохицуулалтын алба нь нөхөн олговор авагчийн хувийн хэрэг, нэрийн картыг шалгах албан бичгийн хамт шилжин очих аймаг, нийслэлийн дүүргийн Хөдөлмөр зохицуулалтын албанд шилжүүлнэ. Албан бичигт нөхөн олговор авагчийн хувийн хэрэг, материалын хуудасны тоо, нөхөн олговор авсан хугацаа зэргийг тодорхой бичнэ.

19. Аймаг, нийслэлийн дүүргийн Хөдөлмөр зохицуулалтын алба нь шилжин ирсэн нөхөн олговор авагчийн хувийн хэрэг, нэрийн карт, тэтгэврийн буюу нөхөн олговрын дэвтр, шилжиж ирсэн тухай тухайн шатны Засаг захиргааны тодорхойлолт бусад холбогдох материалыг шалгасны үндсэн дээр нөхөн олговор үргэлжлүүлэн авах арга хэмжээ авна.

Гурав. Хөдөлмөр зохицуулалтын газрын
үүрэг, хариуцлага

20. Аймаг, нийслэлийн дүүргийн Хөдөлмөр зохицуулалтын албад тухайн газар нөхөн олговор авсан иргэд болон нөхөн олговорт зарцуулсан хөрөнгийн дүнг нэгхүү хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтын дагуу сар бүрийн 3-ны дотор Хөдөлмөр зохицуулалтын газарт гаргаж өгнө.

21. Хөдөлмөр зохицуулалтын газар нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

а) Хөдөлмөр зохицуулалтын газар тухайн сард нөхөн олговор авсан иргэд болон хөрөнгийн дүнг холбогдох маягтуудын дагуу нэгтгэн гаргаж Сангийн яаманд сар бүрийн 3-ны дотор ирүүлж байна.

б) улирлын тайланг Сангийн сайдын 1991 оны 277 тоот тушаалын дагуу гаргаж тогтоосон хугацаанд ирүүлэх бөгөөд холбогдох тайлбар, тодорхойлолтын хамт гаргаж ирүүлнэ.

в) нөхөн олговор авагчдын судалгаа, шаардагдах хөрөнгийн тооцоог нэгтгэн төсөвт тусгуулах, тогтоосон хугацаанд санхүүжилтийн сар бүрийн гүйцэтгэл, мэдээ, улирлын тайланг нэгтгэн ирүүлэх, нөхөн олговрын гүйцэтгэлд яналт тавьж ажиллах.

г) нөхөн олговор авагчдын шилжилт, хөдөлгөөн, нөхөн олговор нь зогсоогдсон болон сэргээгдсэн тухай тооцоо судалгааг сар бүр тогтмол хийн тухайн сард олгох нөхөн олговрын аймаг, нийслэлийн дүүргийн хуваарьтай тооцоог Сангийн яамны Төсвийн бодлогын газарт тухайн сарын 3-ны дотор ирүүлж байна.

22. Сангийн яамны Төсвийн бодлогын газар нь дээрх тооцоо, хуваарийг үндэслэн зохих санхүүжилтийг шуурхай хийж гүйцэтгэж байна.

5803
10-08-24

НӨХӨН ОЛГОВОР АВАГЧИЙН НЭРИЙН КАРТ № . . .

1	Овог, нэр	
2	Төрсөн он, сар, өдөр, нас	
3	Хүйс	
4	Паспортын /үнэмлэх/ №	
5	Дундаж цалин	
6	Хөдөлмөрийн нөхцөл	
7	Хуулийн хэрдүгээр зүйлээр тэтгэвэр тогтоогдсон	
8	Оршин суугаа хэвг	

9	Нөхөн олговор олгох байгууллагын нэр				
10	Нөхөн олговор тогтоолгоод ажиллаж буй байгууллагын нэр, албан тушаал цалингийн хэмжээ				
11	Сарын нөхөн олговрын хэмжээ /усгээр/				
12	Нөхөн олговор олгох хугацаа	Эхлэх	Дуусах		
		он	сар	он	сар
13 аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр зохицуулалтын албаны дарга ахлах нябо				
Карт нээсэн . . . он . . . сар . . . өдөр					

_____ тоот тэтгэвэрийн дэвтрийг хүлээн авсан /эзний гарын үсэг/ _____

НӨХӨН ОЛГОВРЫН ӨӨРЧЛӨЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

№	Өөрчлөлтийн шалтгаан	Сард олгох нөхөн олговор /төг/	Нөхөн олговор олгох хугацаа			Тэмдэглэл хийсэн хүний гарын үсэг	Шалтгаан тухай тэмдэглэл		
			эхлэх он	сар	өдөр		шалтгаан хүний гарын үсэг	өдөр	сар
1									
2									
3									
4									
5									
6									
7									

85

Баягийн сайд, Эрүүл мэнд, нийг-
мийн хамгааллын сайдын 1997
онд А.Т.А/а/гоот тушаалын 4
дүгээр хавсралт

Маягт № НО-03

(байгууллагын нэр)

**НӨХӨН ОЛГОВРЫН ОНЫ ...-Р УЛИРЛЫН
ГҮЙЛГЭЭ БАЛАНС**

Дансны нэр	Эхний үлдэгдэл		Гүйлгээ		Эцсийн үлдэгдэл	
	дебет	кре- дит	дебет	кре- дит	дебет	кре- дит
<u>I. МӨНГӨН ХӨРӨНГӨ</u>						
Касс						
Харилцах (нөхөн олговор)						
<u>II. ЗАРДАЛ</u>						
Төсөвт зардал						
<u>III. ТООЦОО</u>						
Дүн						
Дүн						
I. Нөхөн олговор авагчтай хийх тооцоо						
<u>IV. САН БА САН-ХҮҮЖИЛТ</u>						
Санхүүжилт						
.....						
Олгогдоогүй нөхөн олговор						
Баланс						

Дарга
Ерөнхий (ахлах)
нягтлан бодогч

9503

10 08 24